

ЗӨВ УНШИХ БА ТҮҮНИЙ АРГА ЗҮЙН ТУХАЙ

Ш.Баттөгс¹, дэд профессор, МУБИС

Abstract: Skimming and scanning are two very different strategies for speed reading. People who know how to skim and scan are flexible readers. They read according to their purpose and get the information they need quickly without wasting time. They do not read everything which is what increases their reading speed. Skimming is one of the tools you can use to read more in less time. Skimming refers to looking only for the general or main ideas, and works best with non-fiction material. With skimming, your overall understanding is reduced because you don't read everything. You read only what is important to your purpose. Skimming takes place while reading and allows you to look for details in addition to the main ideas. By reading the first few paragraphs in detail, you will get a good idea of what information will be discussed. Skimming can also be used when reading a newspaper. Often times, people skim the beginning paragraph of an article to determine if it is an interesting read. The main purpose of skimming is to absorb the major ideas of an article while at the same time eliminating the areas of the article that are not applicable to the information being read.

Түлхүүр үг: нэлэнхүйд нь ба түүвэрлэн унших, дэд гарчиг, унших арга зүй, догол мөр

Удиртгал

Аливаа эхийг ойлгох нь ямар сэдвийг юуны төлөө хэрхэн уншихаас их хамааралтай байдаг. Өөрөөр хэлбэл, унших зорилго болон аргаа зөв тодорхойлбол уншлагын үр дүн гарна. Уншлагын эцсийн үр дүн бол хэрэгтэй мэдээллээ богино хугацаанд төвөг багатайгаар олж авахыг хэлж буй хэрэг. Юу хамаагүй зорилгогүй унших нь дэмий цаг үрсэн хэрэг болно. Ялангуяа өнөө цаг үед хэрэгтэй мэдээллээ олохын тулд зөв шилж сонгож унших нь чухал болоод байна. Мөн уншигч бүр юу уншихаас хамаарч өөрийн унших арга техникээ зөв сонгон хэвшүүлэх хэрэгтэй. Уншиж буй сэдвээ илүү богино хугацаанд ойлгох хэд хэдэн арга байдаг. Өгүүлэл, бүлэг, номыг нэгд нэгэнгүй бүтнээр нь унших, зөвхөн гол утга агуулгын эхлэл төгсгөл, утга зангилааг мэдэхийн тулд түүвэрлэн унших, эсвэл гол санааг нь мэдэхийн тулд гүйлгэж унших, хэрэгтэй зүйлээ сонгон унших зэрэг олон арга байна. Энэ өгүүлэлээр сонгосон сэдвээ хэрхэн

зөв унших, хэрэгтэй мэдээллээ яаж олж авах зарим зөвлөгөөг тодорхой үзүүлэхийг зорьсон болно.

Холбоо үгийн утга санааг хурдан ойлгож авах ба хүнд сэдэв унших тухай

Хурдан уншиж ойлгохын тулд нэг хуудсан дээр буй хэд хэдэн үгээс бүтсэн ерөнхий нэг утга агуулгатай, холбоо үгийг анхаарах хэрэгтэй. Нэг, хоёр юм уу, гурван үгийг нэг харцаар харж уншиж байгаа хүн, тав, зургаан үг шууд харж уншиж ойлгож буй хүнээс илүү их цаг хугацаа зарцуулах нь мэдээж. Бид хөнгөн сэдэв бишгүй л уншиж байсан. Харин та илүү хүнд сэдвийг багц мэдээлэл олж авахын тулд хэрхэн уншдаг вэ? Бидэнд хүндхэн сэдэв л асуудалтай байдаг. Мэдээллийг нэг бүрчлэн авахын тулд жирийн хүүрнэсэн өгүүлэл гүйлгэн харж байгаа мэт яаран унших хэрэггүй. Бүтэн цогцолборын утга санааг илэрхийлж буй хэсгийг анхаарлаа төвлөрүүлэн уншихад цаг хугацаа хэрэгтэй. Тийм учраас таны уншлагын хэм хэмжээ буюу нэг минутанд унших үгийн тоо урьдынх шигээ олон биш байх болно. Сэдвийн эхэн болон сүүл хэсэгт байх тайлбарыг эхлээд унших хэрэгтэй.

Гүйлгэж унших

Аливаа номыг эргүүлж байгаад гол утга санааг нь бүрэн илэрхийлж чадах аль нэг бүлэг, хэсгийг сонгон унших арга бий. Энэ аргыг гүйлгэн унших гэж нэрлэх ба маш хурдан хугацаанд агуулгыг мэдэх бололцоотой бөгөөд түүнийг хоёр хувааж үзнэ.

Гүйлгэж унших нь ерөнхий дүр зураг гаргах, утга санааг товчлон илэрхийлэх, дүгнэлт хийхэд маш үр дүнтэй арга билээ. Хуудсуудыг хурдан эргүүлэн харж, гол утгыг илэрхийлж буй үгсийг олох нь гүйлгэн уншиж байгаа хэрэг. Зарим хүн гол санааг тээж буй үгсийг маш хурдан олж харах чадвартай болсон байдаг.

Ерөнхий дүр зураг гаргахын тулд гүйлгэж унших

Танд ашигтай мэдээлэл агуулсан том хэмжээний ном зохиол, бичвэрийн дотроос өөрт хэрэгтэй зүйлээ олж мэдэхийн тулд та гүйлгэж уншвал илүү хурдан үр дүнд хүрнэ.

¹ Shagdarsuren Battugs, Professor. This work was supported by Hankuk University of Foreign Studies Research Fund of 2015

Урьдчилсан дүр зураг гаргахын тулд гүйлгэн унших

Урьдчилсан дүр зургийг гаргах нь ерөнхий дүр зургийг гаргах аас өөр ойлголт юм. Урьдчилсан дүр зургийг гаргахын тулд та аливаа нэг өгүүлэл, бичвэр, сэдвийн гарчиг, дэд гарчиг, онцолсон өгүүлбэр, эхний ба төгсгөлийн цогцолборыг уншихаас гадна бүхий л зураг дүрс, диаграмм хүснэгт зэрэг утга агуулгатай холбоотой бүхэнд анхаарлаа хандуулах хэрэгтэй. Урьдчилсан дүр зураг гаргахын ашиг тустай тал нь:

-Та бичвэрийг нэг бүрчлэн уншиж цаг алдахгүй, зөвхөн өөртөө хэрэгтэй мэдээллээ тоймлон авах

-Та баримтыг хэсэгчлэн авах шаардлагатай үед урьдчилсан дүр зургийг гаргаснаар ерөнхий нэг бүдүүвч зурагтай болж түүнийхээ тусламжтайгаар жижиг хэсгүүдийг зөв харьцаанд оруулах

-Урьдчилсан дүр зургийг гаргаснаар гол санааг нь олж цаашид гүйцэд унших хэрэгтэй эсэхээ шийдэх

Та сонгож авсан сэдвийн урьдчилсан дүр зургийг гаргахын тулд дараах аргыг ашиглах нь зүйтэй. Үүнд:

-Хамгийн түрүүнд гарчгийг нь анхааралтай унш.

Гарчиг өөртөө маш их мэдээлэл агуулсан байдаг бөгөөд танд уг сэдвийн гол түлхүүрийг өгч магад. Заримдаа дэд гарчиг өгсөн байдаг. Эсвэл гарчгийн доорх өгүүлбэр уншигчийг сэдвийг бүхэлд нь уншихаас өмнө гол санааг ойлгуулах зорилгоор бичигдсэн тохиолдол ч байна. Ямар ч тохиолдолд уг сэдэв гарчгаасаа зөрөхгүй бөгөөд шууд бус юм аа гэхэд гарчиг агуулга хоёр дам холбогдох нь бий. Нийтлэлийн болон сонины зарим гарчиг уншигчдын анхаарал татахын тулд сүржин, марзан байдлаар олныг алмайруулах зорилго агуулсан байдаг.

-Хэрэв ямар нэг нүдэнд тусахаар тайлбар, зураг дүрс, хүснэгт байвал тэдний ямар учиртайг нь сайн судлах хэрэгтэй.

-Зураг дүрсийг анхааралтай ажигла. Ямар нэг бие хүн, эд зүйлийн зураг дүрс нь сэдэвтэй ямар хамааралтай болохыг тодруулаарай. Газрын зураг байвал сайн судлах хэрэгтэй. Хэрэв болж буй үйл явдлын газар орныг зөв тогтоож чадвал таны уншиж ойлгоход илүү тустай болох нь дамжиггүй. Хүснэгт диаграмм байвал бичвэрийг уншихаас өмнө сайн харах хэрэгтэй. Энэ танд сэдвийн дотор буй өгөгдөхүүний хэмжээ харьцааг тогтооход тус болно. Зураг дүрсийг дагалдсан бичвэр тайлбарыг бүгдийг нь унших хэрэгтэй.

-Дараа нь уг бичвэрт дэд гарчиг байна уу, үгүй гэдгийг харна. Хэрэв байвал та бүгдийг нь нэг бүрчлэн авах гэж буй мэдээлэлдээ тохируулан гүйлгэж харах хэрэгтэй. Эдгээр дэд гарчиг нь танд бүхэл сэдвийн утга агуулгын чиг хандлагыг танилцуулж өгөх ба ойлгоход бэрх хүнд сэдвийг ойлгож уншихад тус болдог. Заримдаа эдгээр дэд гарчиг танд бүх мэдээллийг өгч чадах тохиолдол ч байдаг. (зөвхөн дэд гарчгуудыг уншаад бичвэрийг бүхэлд ойлгоно гэсэн үг)

-Эхний ба төгсгөлийн цогцолборыг гүйлгэж харах хэрэгтэй.

Хэрэв сүүлд нь дүгнэлт бичсэн байвал танд урьдчилсан дүр төрх гаргахад тус болно.

Түлхүүр үг- (гол үг) ийг хэрэглэж унших

Тодорхой гол үг бусдыгаа бодвол илүү их утга санаа агуулж байдаг билээ. Тогтмол сонин хэвлэлийн өгүүлэл ба номын богино бүлгийн бүх үгийг заавал нэг бүрчлэн унших хэрэггүй байдаг. Хэрэв гол утга санааг илэрхийлсэн үгийг сонгож уншиж чадвал бусад үгсийг орхисон ч гол утга санааг ойлгон авч чадна. Энэ нь унших цагийг хэмнэх болно. Нэр ба үйл үг гол утга санааг агуулж байдаг. Дараа нь тэмдэг нэр орно. *Том, жижиг, хуучин, шинэ, найрсаг, бүдүүлэг, хорттой, ашигтай* зэрэг тэмдэг нэр нь нэр үгтэй холбогдон утга санаанд их өөрчлөлт оруулдаг учраас тэднийг хайхрахгүй өнгөрч болохгүй. *Заримдаа, үргэлж, хатуу, хурдан* гэх мэт байц буюу үйлийн тодотгол нь чухал байх. Аялга ба чимэх үгийн үнэ цэнэ харьцангуй бага байх нь ойлгомжтой. Эдгээр үгс уран зохиолд их нь бий. Цахилгаан мэдээний өгүүлбэрийг хамгийн чухал үгээр сонгон бичдэг. Жишээ болгон захиалсан барааны илгээлтэнд саатал гарсан тухай компаний менежер үйлчлүүлэгчдээ хэрхэн бичиж болохыг авч үзье. Менежер дараах захиаг бичсэн гэж бодъё.

Манай суурь машинд техникийн саатал гарсан учраас танай барааг хүргэж өгөх хугацаа хойшиллоо. 3-р сарын 16 гэхэд хүргэж өгнө.

Тэгвэл түүнийг ингэж бичвэл дээр юм.

Техникийн саатал. Бараа хойшилсон. 3-16 нд очно.

Энэ богинохон цахилгаан утас учир нь, манай, гэхэд, хүргэх, өгөх хугацаа, танай гэх мэтийн үгсийг орхигдуулсан ч гол утгаа хадгалж чадсан байна.

Та ямар нэг бичвэрийг гүйлгэн уншиж байхдаа өөрийгөө цахилгаан утас уншиж байна хэмээн төсөөлбөл зохино. Гол утга санааг хадгалсан үгсийг уншаад бусдыг нь орхиорой.

Нэлэнхүйд нь харах

Гүйлгэж унших (skimming) ба нийтэд харах (scanning) (нэлэнхүйд нь ч гэмээр) хоёр бол өөр ойлголт юм. Гүйлгэж харах үед ерөнхий мэдээллийг авахын тулд бичвэрийг бүгдийг нь уншдаг бол нийтэд нь харах үед уншигч нүдээ бичвэр дээгүүр нааш, цааш гүйлгэн нэгэн тодорхой зүйлийг хайж байдаг. Та өөрийн сонирхон хайж буй ямар нэг зүйлийг бичвэр, цогцолбор, статистик мэдээ, хүснэгт, толь бичиг, лавлах зэргээс хайх үед энэ аргыг хэрэглэх нь их үр дүнтэй юм. Мөн энэ арга нь таныг шалгалтанд бэлтгэж байх үед хүссэн мэдээллээ хурдан олж авахад тус болно. Нэлэнхүйд нь харах арга нь гүйлгэн уншихтай адил олон удаа дасгал хийж сурдаг чадвар юм.

Хэрэв ямар нэг зүйлийг нийтэд нь харах гэж байгаа бол тэр нь чухам таны тэр хэрэгтэй зүйл мөн гэдэгт бат итгэлтэй байх ёстой. Дараа нь тухайн бичвэрийн утга санааг хайхрахгүйгээр хэрэгтэй зүйлээ хайн гүйлгэх хэрэгтэй. Таны хайж буй зүйл тоо байвал бичвэр дундаас тэр нь амархан олдох нь мэдээж. Харин ямар нэг үг, холбоо үгс хайж байгаа бол илүү их анхаарал хандуулбал зохино. Ингэж чадвал таны хэрэгтэй зүйл аяндаа олдох болно.

Тоо баримттай хүснэгтийг нийтэд нь харах дасгал

Хааяа танд тоо бүртгэлийн хүснэгт, диаграмм дотроос тодорхой тоо баримт хайх хэрэг гардаг байх. Та нийтэд нь харах чадварыг сайн эзэмшсэнээр бага хугацааны дотор хэрэгтэй зөв мэдээ баримтаа олж авах боломжтой болно.

Үндсэн санааг нь олох

Хамгийн чухал эзэмшвэл зохих чадварын нэг нь гол санааг олох явдал юм. Энэ нь цогцолборыг маш богино хугацаанд уншиж хэрэгтэй зүйлээ олж авна гэсэн үг юм. Ийм аргыг олон гишүүн бүхий урт өгүүлбэртэй цогцолбор унших үед хэрэглэвэл зохистой. Уншигч үүнийг зөв хэрэглэхгүй бол ийм цогцолборыг хурдан уншиж ойлгоход хэцүү байдаг. Хэрэв урт цогцолборын гол санаа хаана байгааг шууд олж чадвал өөр олон арга хайх хэрэггүй болно. Гол үг нь ихэвчлэн өгүүлэгдэхүүн ба өгүүлэхүүн байх ба гишүүн өгүүлбэр бүр бас ийм гол үгтэйг санах хэрэгтэй. Мэдээж бас нэрийн ба үйлийн тодотгол ч гол үг байх боломжтой юм. Найруулга сайтай цогцолбор үндсэн санаагаа бусдаас илүү тод илэрхийлсэн нэг гол өгүүлбэртэй байдаг. Энэ гол өгүүлбэр таны хайж буй тодорхой баримт, жишээ, утга санааг танд шууд өгч чадна.

Ямар ч тохиолдолд энэ нь тухайн цогцолборын амин сүнс нь байх болно. Та хэрэв гол санааг шууд олж чаддаг болсон бол тэдгээр нь цогцолборын эхэн, дунд, адаг хаанаас ч гарч ирж магад.

Гол санааг нь олохын тулд гүйлгэн унших

Гол утга санааг олохын тулд гүйлгэн уншиж сурвал танд ялангуяа шалгалт өгөх үед үнэлж баршгүй арга барил болно. Та одоо гол санааг олохоор гүйлгэн унших дасгал хийхдээ доорх зааврыг баримтлах хэрэгтэй.

-Уншиж эхэлсэн цаг мөчөө тусгай цаасан дээр тэмдэглээрэй. Цогцолбор бүрээс гол санааг нь олохын тулд гүйлгэн харна. Үг болгоныг унших хэрэггүй. Зүгээр гол санааг олох хүртлээ нүдээ бичвэр дээгүүр бэлчээх хэрэгтэй. Тэр нь заавал эхний өгүүлбэр байх албагүй гэдгийг санаарай. Гол санаа цогцолборын хаана ч байрлаж байж болно. Гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олоод хамгийн чухал утгатай үгсийг сайн харах хэрэгтэй. Уншиж дууссан цагаа бас тэмдэглээрэй. Энэ нь таныг эхээс ямар хугацаанд гол хэсгийг олж байгааг харуулна.

Цогцолбор дундаас чухал, товч хэсгийг олох

Цогцолборын товч хэсгүүд нь жишээ баримт, он цагийн дараалал, харьцуулах, шалтгаан ба үр дагавар, дүн шинжилгээ зэрэг гол санаанд нэмэр болсон хэсэг багтсан байдаг. Товч хэсэг нь гол утга санааг баяжуулан өргөжүүлж утга төгөлдөр болгож байдаг. Гол санаа чухал байдгийг адил товч гол хэсэг ч бас ач холбогдолтой.

Шүүмжилж унших

Та үнэхээр шүүмжилж уншиж чадах уу? Уншиж буй зүйлдээ эргэлздэг үү? Шинэ машин юм уу систем хөгжим авах гэж байгаа хүн эхлээд заавал тэр зүйлээ сайн гэгч шалгаж үздэг. Ямар загвар нь дээр вэ? Хэр зэрэг найдвартай ажиллах бол? Ямар үнэтэй байна?

Шүүмжилж уншина гэдэг бол эргэлзэж тээнэгэлзэн, асууж шалгааж, учрыг нь олж, үнэлж дүгнэн, шүүж, цэнэж уншихыг хэлнэ. Та ямар нэг зүйл худалдан авахтай адил зохиогчийн бодол санааг “худалдаж авахаасаа” өмнө эргэцүүлэн бодох ёстой. Юм болгоныг туйлын үнэн гэж хүлээж авч болохгүй, учир нь хэн нэгэн тэс өөр юм ярьж магадгүй. Бүгдийг бие даан өөрөө үнэлж сурах хэрэгтэй.

Юун түрүүн шүүмжилж унших ёстой зүйл бол зар сурталчилгаа, сонгуулийн мөрийн хөтөлбөр байдаг. Энэ бүлгийг судалснаар та уншсан бүхнээ

эрүүл саруул ухаанаар үнэлж цэгнэн, ухаалаг зүй ёсны шийдвэр гаргах чадвартай болно. Ингэж уншихдаа яарах хэрэггүй, учир нь шүүмжилж уншихад тайван чөлөөтэй бодож эргэцүүлэх хэрэгтэй байдаг. Шүүмжилж уншиж сурснаар та аливаа зүйлийг үнэн зөвөөр ойлгож үнэн худлын алин болохыг ялгаж салгадаг болно.

Баримт, дүгнэлт, сэтгэгдлийн үнэн мөнийг тогтоох

Та аливаа нэг баталгаа, дүгнэлт, сэтгэгдэл уншихдаа заримдаа тэдний найдвартай, үнэн зөв эсэхийг тогтоох шаардлага гардаг. Энэ бүгд үнэн гэдэгт итгэж болох уу? Эдгээр баталгаанд итгэж болох эсэхийг та яаж шийдэх вэ?

Баримтыг үнэлж цэгнэх

Тиймээс аливаа баримт нотолгоо үнэн үү, үгүй юу гэдгийг заавал яг ингэж өөрийн биеэр юм уу өөр мэдээллийн эх булаг ашиглан шалгаж байх хэрэгтэй.

Баримт: Теодор ба Франклин Рузвельт хоёр хамаатан байсан гэсэн мэдээлэл уншаад эргэлзэж байвал нэвтэрхий толь хараад эргэлзээгээ гаргаж болно. Одоо бол интернетээс шалгаж болно.

Индуктив буюу нэгтгэн дүгнэх гаргалгаа

Аливаа нэг зохиогч юм уу, илтгэгч таныг бичиж, ярьж буй зүйлдээ үнэмшүүлэх гэж ятгаж байвал та уншиж сонсож буй бүхнээ шүүмжлэн бодох хэрэгтэй. Тэр бүхнийг үнэн зөвөөр бодож тунгаах нь таны үүрэг юм. Энэ бүгд үнэн баримтад тулгуурласан, зүй ёсны ухаалаг дүгнэлт мөн эсэхийг шийдэх ёстой.

Индуктив буюу хэсгээс бүхэлд шилжүүлэн дүгнэдэг нэг арга байна.

Индуктив арга гэдэг нь хэсэг бусад салангид баримтыг нэгтгэн нэг ерөнхий дүгнэлт гаргахыг хэлнэ.

Жишээ нь: Та хорин ширхэг бүрх малгай байгаа нэгэн харанхуй тасалгаанд орлоо гэж бодъё. Та нэг малгай авч гараад харахад тэр нь улаан өнгөтэй байх юм. Дараа нь бас нэг малгай авч гараад харахад бас л улаан байна. Та дахин арван ширхгийг авч үзэхэд бүгд улаан өнгөтэй байх юм. Ингээд та индуктив аргаар сэтгэж тэр өрөөнд үлдсэн найман малгайг ч харалгүйгээр хорин малгай бүгд улаан өнгөтэй гэсэн дүгнэлтэд хүрч болно.

Таны гаргалгаа худлаа байж болно. Жишээ нь, ганцхан малгай ногоон өнгөтэй байж болох юм. Та малгай бүрийг гартаа барьж үзэж байж үнэн зөв дүгнэлт хийх ёстой. Олон малгай шалгах тусам та

өөртөө улам итгэлтэй болно. Өөрөөр хэлбэл хэдий их баримт цуглуулна, таны индуктив гаргалгаа төдийчинээ үнэн байх боломжтой.

Дедуктив гаргалгаа

Одоо харин бид үүнээс тэс ондоо дедуктив аргын тухай үзэцгээе. Дедуктив арга гэдэг нь ерөнхий зүй тогтол, баталгаатай үнэнээс хэсэг бусад баримт, үйл явцыг ургуулан гаргахыг хэлнэ. Үүнийг тайлбарлахын тулд өнөөх хорин бүрх малгайтай өрөөндөө эргэж очъё. Ингээд хэн нэгэн хүн танд энэ өрөөнд байгаа малгайнууд бүгд улаан өнгөтэй гэж хэллээ. Та нэг малгай сонгож аваад бүгд улаан өнгөтэй гэж танд хэлсэн болохоор та харах ч үгүйгээр тэр малгай улаан гэдэгт итгэлтэй байх юм. Гэхдээ энэ гаргалгаа зөвхөн эхний бүх малгай улаан гэдэг ерөнхий дүгнэлт үнэн байх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл дедуктив гаргалгаанд тулгуурлаж буй ерөнхий байдал үнэн байх хэрэгтэй.

Силлогизм

Силлогизм гэдэг нь ерөнхий ба дам хоёр төрлийн нөхцөлд тулгуурлан дүгнэлт гаргах аргыг хэлнэ. Жишээ нь:

Ерөнхий нөхцөл: Өрөөнд байгаа бүх малгай улаан

Дам нөхцөл: Тэр малгай өрөөнд байна

Гаргалгаа: Тэр малгай улаан

Нийгмийн ухааны сэдэвтэй бичвэр уншихад хэрэгтэй зарим чадвар

Нийгмийн ухааны чиглэлээр суралцаж байгаа та бүхэн гол санаа сэдвийг олох, товч хэсгийн бүтцийг тогтоох, ялгааг судлах, дүгнэлт хийх, уншсанаа эргэн санах, хурдан унших, урьдчилан харах, гүйлгэн унших ба харах, шүүмжлэн унших зэрэг бүх чадварыг ашиглаж сурсан байх ёстой.

Харьцуулал, эсрэлцэл хийхийн тулд уншихуй

Нийгмийн ухааны салбарын бичвэр нь харьцуулах, эсрэлцүүлэн ойлгох чадварыг байнга шаардаж байдаг. Ийм маягийн агуулгатай бичвэрт төр засгийн онол, улс төрчийн бодлого, өөр өөр улсын хөдөө аж ахуй, аж үйлдвэр, тээвэр, байгаль орчны өнгөрсөн ба одоо үеийн нөхцөл байдал, дэлхийн өнцөг булан бүрт байх орны ард түмний өнгөрсөн ба одоо үеийн бэрхшээл гэх мэт сэдэв голлосон байна.

Нийгмийн ухаанд харьцуулал, эсрэлцлийг

заримдаа статистик хүснэгт, диаграмм ашиглан хийдэг. Иймэрхүү хэлбэр нь нийгмийн ухааны салбарт мэдээллийг ойлгомжтой, бага хугацаанд тодорхой харуулж өгдөг.

Хэрэв харьцуулал эсрэлцүүлэл нь таны уншиж байсан энгийн мэдээллийн бичвэртэй адил аргаар хийгдсэн байвал сэдвийн талаар илүү юм бодолгүй уншиж дуусгаж болно. Нөгөө талаас хэрэв та харьцуулсан загварыг хурдан тогтоож адил төстэй ба ялгаатай зүүлт, дүгнэлтийг уншин, бичвэрийг анхааран гол зүйлийг нь тэмдэглэн авбал үр дүн нь гайхалтай сайн байх болно. Ингэж чадвал адил ба ялгаатай тал нь улам тодорч танд тогтооход хялбар болно.

Нийгмийн ухааны сэдэвт бичвэр уншихад юун түрүүн харьцуулал, эсрэгцүүлэл энд хамаатай юу, үгүй юу гэдгийг мэдэж авах хэрэгтэй. Ингэхдээ дараах зүйлийг анхаарах нь зүйтэй.

1. Гарчгийг нь анхаар. Түүнийг сайн анхаарвал нууцыг тайлахад амар болно.

2. Бичвэр дотор харьцуулал, эсрэлцүүлэлтэй холбоотой ямар нэг үг хэллэг байгааг гарчгаас харж шалга.

3. Хэрэв харьцуулал, эсрэлцүүлэл бүхий өгүүлэл байна гэж үзвэл түүний адил ба ялгаатай талыг олж унш.

4. Та бүгдийг тогтоож авахаар мэрийж байгаа бол адил ба ялгаатай талыг бүдүүвчлэн тэмдэглэж дараа хэрэглэхэд зориулж ноорог хийх хэрэгтэй.

5. Хэрэв та судалгааны юм уу, 3-р зүйлд дурдсанаар тогтоож авах зорилгоор унших бол тодорхой цагт багтаах хэрэггүй. Унших цагаа өөрөө сонгосон нь дээр.

Тухайн бичвэрийн чухал үйл явдлыг он цагийн дараалалтай нь холбон тусгаж авах арга

Нийгмийн ухааны сурах бичиг ба лавлахад байнга тохиолдох бичвэрийн загвар нь дараалан болсон томоохон үйл явдал буюу түүхэн чухал цаг үе бүрийг он дарааллын хэлбэрт оруулсан мэдээлэл юм. Үйл явц болон түүхэн үеийн судалгааны хүрээнд хэд хэдэн он цагийг яг таг тогтоосон байх агаад эдгээр нь тухайн нөхцөл байдлыг бүхэлд нь ойлгоход ач холбогдолтой юм.

Шалтгаан ба үр дагаврыг мэдэж авах:

Нийгмийн ухааны бичвэр уншихад байнга тааралдах загварын нэг бол шалтгаан ба үр дагавар юм. Тодорхой нэг шалтгаан тодорхой үр дүн үзүүлж тэр нь дараагийн үйл явдалдаа мөн л үр дагавар үзүүлэх мэтээр цааш үргэлжилнэ. Эдгээр шалтгаан ба үр дагаврыг мэдэж, тэдний хоорондын уялдаа холбоог мэдэрч байх нь нийгмийн ухааны чиглэлийн бичвэр унших гол чадварын нэг юм.

Ерөнхийд нь харж ба судалж унших

Ерөнхийд нь харах буюу гол агуулгатай нь танилцах уншлага нь ерөнхий тойм мэдээлэл авах зорилготой байдаг бол судалж унших гэдэг нь бичвэрийн утга санааг нэг бүрчлэн ойлгож авахыг хэлнэ. Бид ном, сэтгүүл өгүүлэл унших үед энэ аргыг хэрэглэдэг. Бичвэрийн утга санаа бүрийг нэгд нэгэнгүй ойлгох шаардлагагүй, хамгийн гол нь агуулгын талаар хамгийн ерөнхий ойлголтыг, ер нь энэ бичвэрээс тухайн цаг мөчид бидэнд хэрэгтэй зүйл юу байна гэдгийг л харах үед ингэж уншина. Хэрэгтэй мэдээлэл маань энэ бичвэрт байна уу, үгүй юу гэдгийг тодорхойлох зорилготой юм. Ерөнхийд нь харж уншихдаа бид бичвэрийн утгатай ерөнхий байдлаар танилцахаас биш, ямар ямар асуудлыг хөндөн бичсэн байна гэдгийг анхаарах шаардлагагүй гэсэн үг юм. Бичвэрийг уншихаасаа өмнө гарчгийг анхааралтай уншаарай. Гарчиг дахь үгийн утгыг мэдэхгүй бол толь бичгээс харах хэрэгтэй. Утгыг нь мэдэж авсны дараа энэ бичвэрт юуны тухай өгүүлж буйг тааварлах гэж оролдоод үзээрэй.

Ерөнхийд нь гүйлгэж хараад өөрийн таавар үнэн зөв байсан эсэхийг шалгаж болно. Ийм хэлбэрийн уншлага нь дунд сургуулийн сурах бичгийн сэдэв уншихаас илүү хүнд нөгөө талаас үгийн баялаг хэрэгтэй байдаг. Харж уншихад нэг хуудсанд ойролцоогоор 1-1,5 минут зарцуулна. Унших хамгийн гол хэрэгцээнээс гадна боловсрол олгох, хүмүүжүүлэх зорилго үргэлж хамт дагаж явдаг. Бичвэрүүдийг зөв сонгож их уншсанаар бичвэрт буй мэдээллийг ашиглан мэдлэгийн хүрээгээ тэлж өөрийгөө боловсруулахаас гадна аливаа хэлний танин мэдүүлэх үүргийг давхар ухаардаг. Их уншсанаар бодол санаагаа эмх цэгцтэй байлгаж үг хэлээр зөв илэрхийлэх чадвар нэмэгдэнэ. Энэ аргыг бид бичвэрийг гүйлгэн харж ерөнхий утга санаатай танилцах үед хэрэглэнэ.

Энэ бол зөвхөн өөртөө зориулан уншиж байгаа хэрэг юм. Уран зохиолын номыг бид ингэж таашаан уншдаг билээ. Судалж унших аргыг бид тусгай мэргэжлийн ном зохиолыг унших үед хэрэглэнэ. Харах буюу танилцах уншлагаас ялгаатай нь энэ бичвэрт яг юун тухай өгүүлснээс гадна өөр ямар асуудлыг хөндсөн байна гэдгийг судлах хэрэгтэй. Бид бичвэрийн гол утга санаатай танилцаад зогсохгүй, өөрийн бодол санааг харьцуулан үзэж, ном зохиолд гарч буй гол дүрийн онцлогийг тодорхойлж тэдний үйл хөдлөлд үнэлэлт, дүгнэлт өгч чаддаг болох юм. Түүнээс гадна бид уншсан зүйлээ үнэлж цэгнэн, ойлгомжтой, сонирхолтой байсан, өөртөө хэрэгтэй шинэ мэдээлэл олж авч чадсан эсэхээ мэддэг

болно. Бид бичвэрийн хамгийн жижиг хэсгийг хүртэл нэг бүрчлэн ойлгож авах шаардлагатай, тэнд буй тодорхой, бүрэн дүүрэн мэдээллийг олж авч дараа нь шаардлагатай үед судалж уншдаг. Судалж унших үедээ бид уншиж буй сэдвээ удаан хугацааны турш тогтоож, эргэцүүлж байх ёстой гэдгээ сайн мэддэг. Тэгэхлээр бид захидал, заавар, сурах бичгийн өгүүлэл, шалгалт, хяналтын ажлын сэдвийг ингэж унших ёстой. Ном зохиол, сонин сэтгүүлийн өгүүллийн ерөнхий утгыг багцаалан мэдэхийн тулд ерөнхийд нь харах аргыг хэрэглэдэг. Ийм үед утга санааг нэг бүрчлэн ойлгож танилцах шаардлага байдаггүй. Энд хамгийн гол нь сэдвийн хамгийн ерөнхий утга санааг мэдэхэд болно. Юун тухай өгүүлсэн, бидэнд чухал шаардлагатай мэдээлэл байгаа эсэхийг мэдэхэд хангалттай. Хамгийн чухал нь энэ бичвэрт бидэнд хэрэгтэй мэдээлэл байна уу, үгүй юу гэдгийг тодорхойлж мэдэх хэрэгтэй. Ерөнхийд нь харж уншихдаа бид ерөнхий санааг нь мэдэж авахаас биш, аль нэг асуудлын талаар ямар мэдээлэл өгч буйг гүнзгий мэдэх шаардлагагүй юм. Судалж юм уу, ерөнхийд нь харж уншсаны дараа доорх хэсгийг бөглөж түүнийгээ түлхүүртэй тулгаж өөрийгөө шалгаж болно. Багш нар тодорхой сэдвээр уншуулж шалгаж болно. Уншсаны дараа доорх хүснэгтийг бөглөж өөрийгөө хэр зөв уншсанаа түлхүүртэй нь тулгаж шалгаж үзээрэй.

Бичвэрийн дугаар	1	2	3	4
Бичвэрийн нэр				
Бичвэрийн гарчиг сэдэвтэйгээ тохирч байгаа эсэх (тийм/үгүй)				
Түлхүүр ба гол үгс				
Бичвэр утга санаатайгаа тохирч байгаа эсэх (тийм/үгүй)				
Бичвэрийн ямар түлхүүр үгс, холбоо үгс таны сонголттой нийцэж байна вэ?				
Аль бичвэрийг дахин дэлгэрэнгүй унших хэрэгтэйг заана уу.				
Илтгэл, өгүүлэл бэлтгэхэд аль бичвэр илүү тохиромжтойг заана уу.				

Бид юуны тулд уншдаг вэ?

Бид аливаа бичвэрийг зүгээр нэг уншиж буй мэт байвч үнэндээ ямар нэг зорилго заавал байдаг. Бид юу ч уншсан гэсэн ямар нэг мэдээлэл авч шинэ зүйлийг мэднэ. Ямар мэдээлэл олж авах хэрэгтэй байгаагаас шалтгаалан бид уншлагын аль нэг төрлийг сонгон уншдаг.

Бид ямар байрлалд уншдаг вэ?

Уншиж буй бичвэр, хэр сонирхолтой эсэх, ямар учраас уншиж байгаагаас шалтгаалан бид хэвтэж, сууж, эсвэл бүр анхаарлаа төвлөрүүлэн

ширээний ард сууж уншдаг. Эдгээр мөрүүдийг уншаад та дотроо үүнийг хүлээн зөвшөөрч ямар ном зохиолыг яаж уншихаа эргэцүүлэн бодож байгаа байх.

Бид яаж уншдаг вэ?

Тухайн бичвэр бидэнд хэрэгтэй юу, үгүй юу гэдгээс шалтгаалан бид яаж уншихаа сонгодог. Хэрэв та бүр ихийг мэдэж авч, шинэ мэдлэг олж, баталгаа эрж хайх юм уу илтгэл өгүүлэл бичихээр шийдсэн бол яаж унших байсан бэ? Харин та ердөө найз нөхдөө хөгжөөхийн тулд зугаатай түүх уншиж өгч байсан бол тэгтлээ шимтэж унших уу?. Өөр нэг тохиолдлыг авч үзье. Шинэ хөгжим аваад яаж ашиглахыг нь мэддэг хүн тэр бүр байдаггүй, зөвхөн хэрэглэх заавар л аминд ордог. Мөр бүрийг нь хэрхэн яаж анхааралтай унших нь ойлгомжтой. Учир нь та үнэтэй эд зүйлдээ хайнга хандаж шатаахыг хүсэхгүй нь мэдээж. Сонин дэлгээд янз бүрийн зар байна гэж төсөөлье. Тэнд юу зарах худалдан авах нь бидэнд сонин байна. Гэхдээ бид эдгээр ЗАРЫГ хөгжим тоглуулагчийн заавар лугаа адил нэг бүрчлэн анхаарч унших болов уу, эсвэл зүгээр арай сонирхол татах хэсэг дээр зогсож хараад ерөнхийд нь гүйлгээд унших болов уу? Энэ бүгдээс шалтгаалан бид **хурдан, удаан, өнгөц, анхааралтай, сонирхсон, хайхрамжгүй** гэх мэтчилэн уншлагын олон төрлөөс аль нэгийг нь сонгон уншдаг билээ.

Өдгөө цагт их уншихдаа гол бус, харин унших номоо ухаалгаар сонгож байх нь зайлшгүй хэрэгцээтэй болжээ. Ер нь “зөвхөн жинхэнэ сайн номуудыг шилж уншихаас биш оюун ухаанаа хайрлалгүй олон янзын номыг замбараагүй уншаад байвал хүч чадлаа дэмий үрж бүр үгүй хийж ч магадгүй” гэж Оросын нэгэн эрдэмтэн өгүүлсэн байдгийг бид үргэлж санах хэрэгтэй. Хүний ходоод хогийн сав биш учраас идэх юмаа зөв сонгох хэрэгтэй, эс тэгвээс тархи юу дуртайг хүлээж авдаг сав биш учраас унших зүйлээ зөв сонгох хэрэгтэй. Яг үнэндээ бид хэн нэг алдартан нууц хүүхэдтэй, олон амрагтай эсвэл маш том эдлэн газартай гэх мэт хэрэггүй хогон мэдээлэл байнга уншиж байдаг, үнэндээ тэр хүний баян тарган юм уу, юу идэж уудаг нь бидэнд хүртээлгүй, бас тэр мэдээлэл та бидэнд бүр ч хэрэггүй билээ. Тэгэхлээр өнөө цагийн хамгийн чухал асуудал нь уншлагын соёлыг хэвшүүлэх явдал болоод байна. Энэхүү ойлголтод юу багтах вэ? Унших соёл бол өргөн ойлголт. Зүгээр нэг уншихаас эхлээд уншигч зохиогчийн “хамтын бүтээгч” болтол үр бүтээлтэй уншихыг хэлнэ. “Номын сангийн нэр томьёо” толь бичигт унших соёлыг дараах хэсгүүдээс бүрдсэн номтой ажиллах арга барил хэмээн тодорхойлжээ. Үүнд:

- унших сэдвээ ухамсартайгаар сонгох;
- номын сангийн мэдээллийн сан болон арга барилд тулгуурлан эх сурвалжийг тогтоох;
- сонгож авсан номоо зөв үе шаттай, шаргуу уншиж судлах;
- уншиж буй номондоо анхаарлаа төвлөрүүлэн утга санаа агуулгыг нь бүрэн эзэмших;
- утга зохиолын сангаас олж авсан мэдлэгээ амьдралд бүтээлчээр хэрэгжүүлж, ашиглаж сурах;
- Уншсан бүхнээ ой ухаандаа хадгалан тогтоож хэрэгтэй цагтаа ашиг сурах арга барилыг эзэмших;

Энд нэмж тодруулах зүйл гэвэл ном зохиол ба тогтмол хэвлэлтэй гамтай харьцаж, номтой харьцах эрүүл ахуй, сэтгэл санааны үндсэн зарчмуудыг баримтлах, зохион байгуулалттай, ухаалаг зөв, уншлагын олон төрлийг тухай бүр зөв ашиглах, ном хэвлэл, өгүүлэлтэй бүтээлчээр ажиллах зэрэг олон зүйл орно. Унших соёлд орчин үеийн мэдээллийн олон суваг, ялангуяа радио, телевиз, болон олон төрлийн хэвлэлийн материал дунд ном сонин, сэтгүүлийн байрыг зөв тодорхойлох нь чухал. Унших соёл гэдэг бол удаан хугацааны турш ба “тэрхэн зуурын” хооронд унших зорилгоо зөв тодорхойлж ном хэвлэлээ богино хугацаанд хайж олоод хурдан үр бүтээлтэй ашиглахыг хэлнэ. Унших соёл гэдэг бол уншиж буй бичвэр ойлгоход хичнээн хэцүү, төвөгтэй байсан ч оюун ухаан сэтгэл хөдлөл, ургуулан бодох чадвараа дайчлан байж гол утга санааг ойлгож чаддаг байхыг хэлнэ. Энэ бол уншсан зүйлээ сайн ойлгож авах нь уншигчийн хамгийн сайн чанар юм. Унших соёлын бас нэг чухал хэсэг нь номын сангийн талаар өндөр мэдлэгтэй байх явдал юм. Номын сангийн дүрэм, журмыг сайн мэддэг, каталог ашиглан хэрэгтэй номоо олж чаддаг, өөрийн сонирхдог салбарт шинээр гарсан ном зохиолыг цаг тухайд нь олж авдаг, ном хэвлэлтэй холбоотой лавлах материалуудыг байнга ашигладаг байх хэрэгтэй.

Шинжлэх ухааны зохиол болон уран зохиолын ном унших нь олон талаар ялгаатай зүйл юм. Тусгай мэргэжлийн ном зохиол болон тогтмол хэвлэлийг юуны өмнө зохион байгуулалттайгаар унших хэрэгтэй бол уран сайхны зохиол, үргэлжилсэн үгийн ба яруу найргийг өөрийн сэтгэлийн хөөрлийг бүрэн зориулж, эх хэлээ хайрлах сэтгэлээр “үгэн доторх үгийн” утгыг мэдрэн, бүрэн таашаал авч унших хэрэгтэй. Сэтгэл зүйч эрдэмтэд “мэргэжлийн уншигч” (мастер уншигч) ямар чадвартай байх талаар судалгаа хийж дараах дүгнэлтийг гаргажээ. Үүнд:

• Ашиглах чадвар:

Бичвэрийн гол утга санааг бусад товч хэсгийн тусламжтайгаар тогтоож чаддаг байх

Бичвэрийн хэсэг бүрийн харилцаа холбоог тогтоох

Номын сангийн болон лавлах бичгийг байнга ашигладаг байх

Нэмэлт материал уншлагадаа байнга ашиглах

Хурдан унших аргуудыг хэрэглэдэг байх

Янз бүрийн санал таамаглал төлөвлөн, шалгах аргаа сонгох

Уншиж буй бичвэртээ дүн шинжилгээ хийж бусадтай харьцуулан задлан шинжлэх

• Төсөл зохиох чадвар:

Унших зорилгоо тодорхойлох, унших үйл ажиллагаандаа хариуцлагатай хандах

Бие даан судалгаа хийх ба мэдээллийн янз бүрийн эх сурвалжтай ажиллах чадвар

Ямар аргаар ном хэвлэлтэй ажиллан хэрхэн үр дүнд хүрэх арга замаа боловсруулах

Уншлагын зорилго, хурд, хэмнэлийг тогтох

• Үндсэн гол чадвар:

Товч, тодорхой, өөрийн үгээр энгийн жишээ татах

Ном, өгүүлэлд буй мэдээ, мэдээлэлд тулгуурлан төлөвлөгөө зохиох,

Өөрийн мэдээллийг баталгаажуулах

Иш татах, товчлох, хураангуйлах, шүүмжлэх

Дүгнэлт хийх

• Харилцаа, мэдээллийн чадвар:

Судалж буй бичвэртээ асуулт зохиох

Ном хэвлэлийн тухай мэдээллийг цуглуулан дүн шинжилгээ хийх

Ном, өгүүлэл шүүмжлэн хэлэлцэхэд өөрийн биеэр идэвхтэй оролцох

Уншлагын явцад олж авсан мэдлэгээ бусадтай хуваалцах

Уншсан номынхоо тухай илтгэл тавьж, үнэн зөв дүгнэлт гаргах

Уншсан номынхоо талаар өөрийн сэтгэгдлийг илэрхийлж, дүгнэж цэгнэх

• Зохион байгуулах чадвар:

Цагаа зөв зохицуулан, дэмий хоосон цаг үрэхгүй байх

Ажлын байр, хэрэгтэй багаж материал бэлтгэх, эрүүл ахуйн байдлыг хангах, ажлын хэм хэмнэлийг байнга хянаж байх

Нүдний хараа, харааны хөдөлгөөн, ядарч
байгаа эсэхийг байнга хянах

Тодорхой зорилго тавин уншиж байх үедээ
бусадтай харилцахгүй байх

Зөв унших дадлагыг байнга хийх

Унших явцад хурааж цуглуулсан мэдээллийг
дараа нь амьдралдаа хэрэглэж сурах

ДҮГНЭЛТ

Ингэхлээр унших соёл гэдэг маань уншигчдад
зайлшгүй байх ёстой ном хэвлэлийн зорилго, үнэ
цэнэ, агуулгыг ойлгож мэдэх, түүнтэй харьцах
чадвар, арга барил юм. Мэргэжлийн уншигч
болохоор тэмүүлж буй хэн бүхэн эдгээр чадварыг
эзэмших ёстой. Эцэст өгүүлэхэд аливаа зүйлд
цэгцтэй, ухамсартай хандаж сурах нь зөв уншиж
сурахтай их холбоотой, нөгөөтэйгүүр ашигтай,
хэрэгтэй мэдээллийг богино хугацаанд олж авна
гэдэг нь зөвхөн их уншсанаар хязгаарлагдахгүй,
түүнийг хэрхэн ухамсартай уншсанаар хэрэгжинэ
гэдгийг сайн мэдэх хэрэгтэй. Ийм зөв унших чадвар
дадлыг хүүхдэд шат дараалан сургах хэрэгтэй юм.
Үүний тулд багш бэлтгэдэг сургуульд, ялангуяа
бага ангийн багшийн ангид суралцагч оюутанд
ийм хичээл их чухал санагдана. Бидэнд хүүхдийг
хурдан уншуулж сургахдаа гол бус, зөв уншуулж,
хэрэгтэй мэдээллийг олж, хэрэглэж чаддаг болгон
сургах нь чухал болж байна.

АШИГЛАСАН НОМ

Nila Banton, Smith. (1984). Be a better reader

Гомбосүрэн, Р. (1989). *Ном эзэмших соёл*.

Улаанбаатар

Дэйл, Карнеги. (1998) “цуврал бүтээлүүд” Монгол

орчуулга. Улаанбаатар

Оюун-Эрдэнэ, Л. (2015). Алсын хараа. Улаанбаатар